



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/455

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 150 ширхэг жуух бичиг, 350 ширхэг өргөмжлөл захиалан хийлгэх зардалд 6 500 000 төгрөг, Ардын хувьсгалын 100 жилийн ойгоор ахмадуудад бэлтгэсэн гарын бэлэгний зардалд 1 457 000 төгрөг, Шилдэг ахмадын холбоогоор шалгарсан Мөнххайрхан сумын ахмадын холбооны шагналын зардалд 260 000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрхи арга хэмжээнүүдэд зарцуулах 8 217 000 төгрөг /Найман сая хоёр зуун арван долоон мянган/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ